



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 112

Ховд

Хөрөнгө шилжүүлэх зөвшөөрөл
олгох тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 87 дугаар тогтоолоор баталсан журмын 5.1 дэх заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Булган сумын Нэгдсэн эмнэлгийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 14312300 төгрөг /арван дөрвөн сая гурван зуун арван хоёр мянга гурван зуу/-ийн балансын үнэ бүхий үлдэх өртөггүй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн Ланд ровер Дефендер маркийн суудлын автомашиныг аймгийн Орон нутгийн өмчийн газарт балансаас, балансад шилжүүлсүгэй.

2. Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад үндсэн хөрөнгийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх ажлыг зохион байгуулахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ш.Нохойжав, Булган сумын Нэгдсэн эмнэлгийн эрхлэгч /Б.Батбаатар/ нарт даалгасугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ш.Нохойжав/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 113

Ховд

Хөрөнгө шилжүүлэх санал
уламжлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.2, 31.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 87 дугаар тогтоолоор баталсан журмын 5.1 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Ховд аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын балансад бүртгэлтэй Ланд круйзер Прадо-150 маркийн, 19-66 ХОУ улсын дугаартай, KNGGBK1V2BK002800 арлын дугаартай, 2011 онд үйлдвэрлэсэн нийт 68989800 төгрөг /жаран найман сая есөн зуун наян есөн мянга найман зуу/-ийн балансын үнэтэй, 2874575 төгрөг /хоёр сая найман зуун далан дөрвөн мянга таван зуун далан тав/-ийн хуримтлагдсан элэгдэл бүхий тээврийн хэрэгслийг Ховд аймгийн Засаг даргын Тамгын газарт балансаас балансад шилжүүлэх саналыг дэмжин Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт уламжилсугай.

2.Хөрөнгийн шилжүүлэх асуудлыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг дарга /Б.Дүгэржав/, Орон нутгийн өмчийн газрын дарга /Ш.Нохойжав/ нарт үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 114

Ховд

Үндсэн хөрөнгө бүртгэх
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйл, 77 дугаар зүйлийн 77.3, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх шилжүүлэх, худалдах, акталж устгах, данснаас хасах, тайлагнах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.7, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улсын болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хавсралтад тусгагдсан 534088254 төгрөг /таван зуун гучин дөрвөн сая наян найман мянга хоёр зуун тавин дөрөв/-ийн балансын үнэ бүхий үндсэн хөрөнгийг балансад бүртгэхийг Чандмань сумын Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Ганзориг/-д зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулж нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэн, ашиглалтыг хариуцаж ажиллахыг Чандмань сумын Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Ганзориг/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ш.Нохойжав/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны
04 сарын 24-ны өдрийн 114 дугаар
тогтоолын хавсралт



ЧАНДМАНЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН БАЛАНСАД
БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

/ Төгрөгөөр /

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон он сар	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Балансад бүртгэх үнэ
Зам						
1	Цементэн зам	2016	м	600м	400,000,000	400,000,000
2	Явган хүний зам	2016	м	600м	33,238,648	33,238,648
	ДҮН				433,238,648.0	433,238,648
Нийтийн эзэмшил						
3	Ногоон байгууламж	2016	ш	1	30,000,000.0	30,000,000.0
	ДҮН			1	30,000,000.0	30,000,000
Барилга, байгууламж						
4	Ахмадын байр	2018	ш	1	33,392,606	33,392,606
5	Мал нядалгааны цэг	2013	ш	1	9,000,000	9,000,000
6	Сүлжээ багийн төвийн барилга	2013	мкв	1	28,457,000	28,457,000
	ДҮН			2	70,849,606	70,849,606
Тоног төхөөрөмж						
	НИЙТ ДҮН			3	534,088,254	534,088,254
/Таван зуун гучин дөрвөн сая наян найман мянга хоёр зуун тавин дөрөв/						

...о0о...



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 115

Ховд

Нээлттэй дуудлагын худалдаа
зарлах тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 77 дугаар зүйлийн 77.3, Төрийн өмчийн Бодлого зохицуулалтын газрын 2019 оны 268 дугаар тогтоолын 4.3, 4.4 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тээврийн хэрэгслийн доод үнийг 1 дүгээр хавсралтаар, үл хөдлөх хөрөнгийн доод үнийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

2.Нээлттэй дуудлагын худалдааг аймгийн Нутгийн удирдлагын ордонд болон хөрөнгө байрлаж буй тухайн орон нутагт нь 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс 2020 оны 06 дугаар сарын 04-ны өдрүүдэд тус тус зохион байгуулсугай.

3.Нийтийн дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн зарыг олон нийтэд ил тод мэдээлж, холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулан борлуулсан орлогыг аймгийн өмчийн санд төвлөрүүлэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтөд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ш.Нохойжав /-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны
15 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИН, ТЭЭВРИЙН
ХЭРЭГСЭЛИЙН ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ БОЛОН ХУДАЛДАХ ҮНИЙН САНАЛ

Д/д	Эзэмшигч байгууллагын нэр	Худалдах хөрөнгийн нэр, марк	Ашиглалта нд орсон он	Ашиглалтын талаарх мэдээлэл								Болох газар, хугацаа
				А/жил	Улсын дугаар	Өнгө	Арлын дугаар	Балансын үнэ	Х/элэгдэл	Үлдэх өртөг	Үнийн санал	
1	Аймгийн Эрүүл мэндийн газар	Ланд круйзер Прадо-76	200/2011	9	4463 ХОУ	цагаан	810064896	56,471,313	56,471,313	0	3,500,000	Аймгийн Нутгийн удирдлагын ордон 2020.05.29-нд
2	Үенч сумын Засаг даргын Тамгын газар	УАЗ-469	2011/2011	9	3105 ХОУ	бор ногоон	90876543	21,300,000	21,300,000	0	3,000,000	Үенч сумын ЗДТГ 2020.06.02-нд
3	Дарви сумын Засаг даргын Тамгын газар	Ковш/шана гатай ачигч/	2013/2013	7	3305 УН	шар	208061713	30,000,000	30,000,000	0	1,000,000	Дарви сумын ЗДТГ 2020.06.04-нд
4	Дарви сумын Засаг даргын Тамгын газар	Кама /ачааны, өөрөө буулгагч	2013/2013	7	4284 ХОУ	цэнхэр	1490	20,000,000	20,000,000	0	500,000	Дарви сумын ЗДТГ 2020.06.04-нд

5	Дарви сумын Засаг даргын Тамгын газар	УАЗ- Фермер	2010/2011	9	5501 ХОА	саарал	433228	19,990,000	19,990,000	0	600,000	Дарви сумын ЗДТГ 2020.06.04-нд
6	Дарви сумын Засаг даргын Тамгын газар	Пад пад	2010	10		улаан		1,909,565	1,909,565	0	100,000	Дарви сумын ЗДТГ 2020.06.04-нд
7	Дарви сумын Засаг даргын Тамгын газар	ХАА-н СКН	2010/2010	10		улаан		10,282,000	10,282,000	0	1,000,000	Дарви сумын ЗДТГ 2020.06.04-нд
8	Дарви сумын Цагдаагийн газар	Ланд круйзер-80	1993/2011	9	8089 УНГ	хар ногоон	10033793	26,000,000	26,000,000	0	1,500,000	Дарви сумын ЗДТГ 2020.06.04-нд
9	Дарви сумын ЕБС	УАЗ-Фургон	2008/2008	12	7384 ХОА	саарал	80441577	20,000,000	20,000,000	0	600,000	Дарви сумын ЗДТГ 2020.06.04-нд
10	Ховд сумын Засаг даргын Тамгын газар	УАЗ- Фермер	2010/2011	9	5516 ХОА	саарал	433377	19,900,000	19,900,000	0	600,000	Аймгийн Нутгийн удирдлагын ордон 2020.05.29-нд
НИИТ ДҮН					0	0	0					

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны
 115 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

/ төгрөгөөр /

№	Эзэмшигч байгууллагын нэр	Ашиглалтанд орсон он	Ашиглах хугацаа	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Үнийн санал	Болох газар, хугацаа
1	Мөст сумын Цагдаагийн хуучин байр	2008	36	8,780,000	2,926,667	5,853,333	300,000	Мөст сумын Нутгийн удирдлагын ордон 2020.05.27-нд
2	Мөст сумын 3-р багийн өвлийн төв	2007	36	4,876,400	1,625,467	3,160,933	100,000	Мөст сумын Нутгийн удирдлагын ордон 2020.05.27-нд
3	Зэрэг сумын ЗДТГ Гараж	1981	36	4,204,000	4,204,000	-	300,000	Зэрэг сумын Нутгийн удирдлагын ордон 2020.05.28-нд
4	Зэрэг сумын ЗДТГ Халуун усны барилга	2012	36	3,500,000	753,472	2,746,528	600,000	Зэрэг сумын Нутгийн удирдлагын ордон 2020.05.28-нд
5	Цэцэг сумын ЗДТГ /Хөшөөт багийн цэцэрлэг/	1987	18	103,825,869	103,825,869	-	1,000,000	Цэцэг сумын Нутгийн удирдлагын ордон 2020.05.28-нд
6	Үенч сум Цагаан түнгэ багийн төв	1963	36	9,411,600	9,411,600	-	300,000	Үенч сумын Нутгийн удирдлагын ордон 2020.06.02-нд
7	Үенч сум Жаргалан багийн контор	1995	36	8,510,900	5,752,738	2,758,162	300,000	Үенч сумын Нутгийн удирдлагын ордон 2020.06.02-нд
8	Үенч сум Улиаст багийн контор	2007	16	3,542,000	2,910,022	631,978	300,000	Үенч сумын Нутгийн удирдлагын ордон 2020.06.02-нд
9	Үенч сум Цагаан түнгэ багийн барилга	1963	36	5,313,000	5,313,000	-	500,000	Үенч сумын Нутгийн удирдлагын ордон 2020.06.02-нд
10	Үенч сум Улиаст багийн Улаан булан	1995	36	3,946,800	3,946,800	-	300,000	Үенч сумын Нутгийн удирдлагын ордон 2020.06.02-нд
11	Үенч сум Нарийн гол багийн хуучин контор	1973	36	4,056,000	4,056,000	-	300,000	Үенч сумын Нутгийн удирдлагын ордон 2020.06.02-нд
НИЙТ ДҮН				159,966,569	144,725,634	15,150,935		



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 116

Ховд

Нээлттэй дуудлагын худалдаа
дахин зарлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 77 дугаар зүйлийн 77.3, Төрийн өмчийн Бодлого зохицуулалтын газрын 2019 оны 268 дугаар тогтоолын 4.3, 4.4 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн “Нийтийн дуудлагын худалдаа зарлах тухай” 2013 оны 158, “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 2014 оны 20, 52, 2017 оны 112, дугаар тогтоолоор зарласан нийтийн дуудлага худалдаагаар борлуулагдаагүй Дуут сумын Соёлын төвийн барилга, 2017 оны 116 дугаар тогтоолоор худалдан борлуулагдаагүй Мөст сумын Цэцэрлэгийн хуучин барилга, сургуулийн барилгыг чөлөөлөн худалдан борлуулах хавсралтад заасан бусад үндсэн хөрөнгийн үнийг бууруулж худалдах доод үнийг нэгдүгээр хавсралтаар, тээврийн хэрэгслийн худалдах доод үнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Нээлттэй дуудлагын худалдааг аймгийн Нутгийн удирдлагын ордонд болон хөрөнгө байрлаж буй тухайн орон нутагт нь 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс 2020 оны 06 дугаар сарын 04-ны өдрүүдэд тус тус зохион байгуулсугай.

3. Нийтийн дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн зарыг олон нийтэд ил тод мэдээлж, холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулан борлуулсан орлогыг аймгийн өмчийн санд төвлөрүүлэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтөд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ш.Нохойжав /-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны
116- дугаар тогтоолын 1 дугаар хавсралт

ДАХИН ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИН, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛИЙН ТЕХНИКИЙН
ҮЗҮҮЛЭЛТ БОЛОН ХУДАЛДАХ ҮНИЙН САНАЛ

Д/д	Эзэмшигч байгууллагын нэр	Худалдах хөрөнгийн нэр, марк	Ашиглалтанд орсон он	Ашиглалтын талаарх мэдээлэл					Х/элэгдэл	Үлдэх өртөг	Үнийн санал	Болох газар, хугацаа
				А/жил	Улсын дугаар	Өнгө	Арлын дугаар	Балансын үнэ				
1	Дөргөн сумын ЗДТГ	Ланд круйзер-80	1996/2011	9	6943ХОУ	ногоон	810064896	25,000,000	25,000,000	-	1,500,000	Аймгийн Нутгийн удирдлагын ордон 2020.05.29
2	"Шим-Ус"ОНӨААТҮГ	Тоёота Марк-2	2001/2010	10	6125ХАО	саарал	6018584	9,500,000	9,500,000	-	800,000	Аймгийн Нутгийн удирдлагын ордон 2020.05.29
3	Хот тохижуулах газар	Хюндай Портер	2001/2007	13	2757ХОА	цагаан	14458187	8,302,800	8,302,800	-	300,000	Аймгийн Нутгийн удирдлагын ордон 2020.05.29
4	Хот тохижуулах газар	ZL-30 авто ачигч	2007/2007	13	4829УБ	шар	20071730	18,309,025	18,309,025	-	4,000,000	Аймгийн Нутгийн удирдлагын ордон 2020.05.29
5	Буянт сумын Эрүүл мэндийн төв	УАЗ-315122	2009/2009	11	4566ХОА	цагаан	90541292	19,677,000	19,677,000	-	2,500,000	Аймгийн Нутгийн удирдлагын ордон 2020.05.29
6	Цагдаагийн газар	УАЗ-220692-033 / Пургон/	2012/2012	8	0075ХОУ	хар	4733653	20,600,000	20,600,000	-	800,000	Аймгийн Нутгийн удирдлагын ордон 2020.05.29
7	Манхан сумын Соёлын төв	УАЗ-220692-033	2010/2010	10	2649ХОА	саарал	70428009	10,000,000	10,000,000	-	1,500,000	Аймгийн Нутгийн удирдлагын ордон 2020.05.29
8	Чандмань сум "Чандмань-БИТ"	Исузу /ачааны/	1995/2011	9	4779ХОА	цагаан	740084	9,500,000	9,500,000	-	500,000	Аймгийн Нутгийн удирдлагын ордон 2020.05.29
НИЙТ ДҮН					0	0	0	120,888,825	120,888,825			

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны
116 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



ДАХИН ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

/ Төгрөгөөр /								
№	Эзэмшигч байгууллагын нэр	Ашиглалтанд орсон он	Ашиглах хугацаа	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Үнийн санал	Болох газар, хугацаа
1	Мөст сумын Цэцэрлэгийн хуучин барилга	1981	40	89,910,800	89,910,800	-	5,000,000	Мөст сумын Нутгийн удирдлагын ордон 2020.05.27-нд
2	Мөст сумын ЕБС-ын Дотуур байр	1973	20	144,998,280	144,998,280	-	10,000,000	Мөст сумын Нутгийн удирдлагын ордон 2020.05.27-нд
3	Мөст сумын Халуун усны хуучин барилга	2000	15	5,040,000	5,040,000	-	500,000	Мөст сумын Нутгийн удирдлагын ордон 2020.05.27-нд
4	Дуут сумын Соёлын төвийн хуучин барилга	1991	60	286,910,300	138,673,312	148,236,988	5,000,000	Аймгийн Нутгийн удирдлагын ордон 2020.06.03-нд
5	Мянгад сумын Моторын байр	1980	40	2,646,000	2,646,000	-	500,000	Мянгад сумын ЗДТГ 2020.06.05-нд
7	Мянгад сумын ЗДТГ-ын орон сууц	1972	40	3,780,000	3,780,000	-	2,000,000	Мянгад сумын ЗДТГ 2020.06.05-нд
8	Мянгад сумын Гахайт багийн контор	1995	15	4,725,000	4,725,000	-	300,000	Мянгад сумын ЗДТГ 2020.06.05-нд
6	Буянт сумын Цахилгаан станцын байр	1968	60	52,384,000	51,356,863	102,713,725	300,000	Буянт сумын ЗДТГ 2020.06.05-нд
9	Зэрэг сумын ЕБС-ын Гал тогооны барилга	1979	40	34,860,000	34,860,000	-	3,500,000	Зэрэг сумын ЗДТГ 2020.05.28-нд
10	Чандмань сумын Тахилт багийн хуучин контор	1999	15	1,619,200	161,920	-	300,000	Чандмань сумын ЗДТГ 2020.05.28-нд
НИЙТ ДҮН				626,873,580	476,152,174	250,950,713		

.....ооо.....



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 117

Ховд

Төрийн дээд шагналаар шагнуулахаар
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэлийг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улс нийгэмдээ олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаа дараах хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй. Үүнд:

Монгол Улсын “Ардын эмч”-ээр

- | | |
|---|---|
| 1. Тумаг Янжмаа | - Зэрэг сумын Хөндлөн багийн өндөр настан |
| “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-гоор | |
| 1. Ванчиг Баярхүү | - Алтай сумын Алтангадас багийн өндөр настан |
| 2. Эрхэмбаяр Должинсүрэн | - Манхан сумын Төгрөг гол багийн өндөр настан |
| 3. Мягмар Баатархүү | - Зэрэг сумын Хөндлөн багийн өндөр настан |
| 4. Галигаа Байгальмаа | - Зэрэг сумын Хөндлөн багийн өндөр настан |
| 5. Санжаа Цэрэнжамц | - Ховд аймгийн Жаргалант сумын иргэн |
| 6. Хорлоо Батнасан | - Жаргалант сумын Тахилт багийн өндөр настан |
| 7. Цэнд-Аюуш Отгондалай | - Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын өндөр настан |
| 8. Доржсүрэн Төмөрбаатар | - Мянгад сумын ЕБС-ийн ахмад багш |

“Алтангадас одон”-гоор

- | | |
|----------------------------|---|
| 1. Жавзан Долгор | - Мянгад сумын Баянхошуу багийн
өндөр настан |
| 2. Шагдар Даваахүү | - Мянгад сумын ЕБС-ийн багш |
| 3. Батаа Даваасүрэн | - Мянгад сумын ЕБС-ийн сантехникч |
| 4. Доржсүрэн Төмөрбаатар | - Мянгад сумын ЕБС-ийн багш |
| 5. Бат-Очир Цэрэнбадам | - Мянгад сумын ЕБС-ийн багш |
| 6. Хойлог Сонинтөр | - Алтай сумын Алтангадас багийн
өндөр настан |
| 7. Пунцаг Ганболд | - Алтай сумын Алтангадас багийн
малчин |
| 8. Сунгарав Отгоо | - Алтай сумын Бодонч багийн малчин |
| 9. Жанчив Төмөрбаатар | - Алтай сумын Алтангадас багийн
малчин |
| 10. Дамдинбазар Батжаргал | - Зэрэг сумын Хөндлөн багийн өндөр
настан |
| 11. Гайран Авирмэд | - Манхан сумын Улаанхүрээ багийн
өндөр настан |
| 12. Дамдин Ханджав | - Манхан сумын Улаанхүрээ багийн
өндөр настан |
| 13. Моломжав Оюунцэцэг | - Чандмань сумын Урд гол багийн
өндөр настан |
| 14. Дүгэр Цэндхүү | - Чандмань сумын Урд гол багийн
өндөр настан |
| 15. Жигмэд Нямсүрэн | - Эрдэнэбүрэн сумын Хонгио багийн
өндөр настан |
| 16. Жанагаа Батжаргал | - Жаргалант сумын Буянт багийн
өндөр настан |
| 17. Цэдэвсүрэн Төмөрбаатар | - Жаргалант сумын Наран багийн
өндөр настан |

“Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар

- | | |
|----------------------|--|
| 1. Өлзийбат Дариймаа | - Манхан сумын Улаанхүрээ багийн
өндөр настан |
| 2. Жур Сэржмаа | - Манхан сумын Улаанхүрээ багийн
өндөр настан |
| 3. Цэвээн Цэцэгсүрэн | - Манхан сумын Төгрөг гол багийн
өндөр настан |
| 4. Төлөвхан Самет | - Үенч сумын Жаргалан багийн өндөр
настан |

- | | |
|------------------------|---|
| 5. Чурай Пүрэв | - Жаргалант сумын Тахилт багийн
өндөр настан |
| 6. Дагважанцан Ганхуяг | - Чандмань сумын ЕБС-ийн нярав |
| 7. Шархүү Байгалмаа | - Ховд аймгийн Музейн үйлчилгээний
ажилтан |
| 8. Хумбаа Бямбасүрэн | - Ховд аймгийн Музейн эрдэм
шинжилгээний ажилтан |
| 9. Гоёвоон Дандар | - Алтай сумын соёлын төвийн эрхлэгч |
| 10. Соном Пүрэв | - Мянгал сумын ЕБС-ийн нярав |
| 11. Наваан Даваацэрэн | - Мянгад сумын ЕБС-ийн жижүүр |

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 118

Ховд

Үндсэн хөрөнгө бүртгэх
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйл, 77 дугаар зүйлийн 77.3, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж устгах, данснаас хасах, тайлагнах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улсын Онцгой Комиссын хандив тусламжаар 2019 онд нийлүүлсэн УАЗ-2206 маркийн, УНӨ 78-20 улсын дугаартай, нийт 29100000 төгрөг /хорин есөн сая нэг зуун мянга/-ийн үнэ бүхий автомашиныг хөрөнгийн бүртгэлд тусгахыг Ховд аймаг дахь Цэргийн гавьяаны одонт Цагдаагийн газрын дарга /Э.Даваасүрэн/-д зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулж нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэн, ашиглалтыг хариуцаж ажиллахыг Ховд аймаг дахь Цэргийн гавьяаны одонт Цагдаагийн газрын дарга /Э.Даваасүрэн/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ш. Нохойжав/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ